



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1.2, 92 дугаар зүйлийн 92.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.16, "Арилжааны журам"-ын Хавсралт 1-ийн 6 дахь заалт, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 22.10 дахь заалт, Аудитын хорооны 2025 оны 04 сарын 01-ний өдрийн ... дугаартай дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор Сангийн яамтай "Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг гүйцэтгүүлэх тухай гэрээ"-г байгуулах зөвшөөрлийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д олгосугай.
2. "Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг гүйцэтгүүлэх тухай гэрээ"-нд анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийн хэмжээг худалдагч талаас 0.03-0.06 хувийн хооронд, худалдан авагч талаас 0-0.00875 хувийн хооронд байхаар, үнэт цаас гаргагчаас үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлс авахгүй байхаар тус тус үнэт цаас гаргагчтай харилцан тохиролцож тусган, арилжааны бэлтгэл ажлыг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525617051